

2021.03.24

**ТА ИНТЕРНЕТ БАНК БОЛОН 319708, 319709
УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ
ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.**

Валют	Ханш	24H Chg
EUR/USD	1.1847	-0.02%
USD/CNY	6.5251	-0.16%
USD/RUB	76.3853	0.01%
USD/JPY	108.5	-0.08%
USD/KRW	1134.05	0.39%
USD/CHF	0.934	1.96%
AUD/USD	0.7601	0.19%
GBP/USD	1.373	0.00%

Индекс	Нэгж	24H Chg
Dow Jones	32423.2	-0.94%
S&P 500	3910.5	-0.76%
NASDAQ	13227.7	-1.12%
FTSE 100	6699.2	-0.40%
Nikkei 225	28465.9	-1.83%
DAX	14662.0	0.03%
Hang Seng	28028.0	-1.65%
SHCOMP	3384.4	-0.80%

Метал	Ханш (USD)	24H Chg
Алт	1732.63	0.32%
Мөнгө	25.1895	0.51%
Нүүрс (Чин хуанг дао)	97.78	1.02%
Хүрэн нүүрс (БНХАУ)	33.3	-0.09%
Зэс (LME)	8980	-1.41%
Төмрийн хүдэр	3384.387	-0.80%
Газрын тос (NYME)	57.77	0.02%

Бонд	Хүү	24H Chg
US 1M LIBOR	0.11%	-0.92%
US 3M LIBOR	0.19%	-3.24%
US 6M LIBOR	0.20%	0.86%
US 12M LIBOR	0.28%	0.00%
US Treasury 10Y	1.60%	-1.19%
UK Treasury 10Y	0.76%	-6.27%
GE Treasury 10Y	-0.34%	-9.65%
JP Treasury 10Y	0.07%	-9.76%

Бонд (Монгол)	Хүү	Дуусах огноо	Өгөөж	24H Chg
Мазаалай	10.8%	4/6/2021	-0.85%	0.02%
МИК 2022	9.75%	1/29/2022	8.20%	-0.01%
Чингис	5.13%	12/5/2022	3.02%	-0.08%
Гэрэгэ	5.63%	5/1/2023	3.07%	-0.07%
МУХБ 2023	7.25%	10/23/2023	3.67%	0.06%
Хуралдай	8.75%	3/9/2024	3.15%	-0.05%
ММС	9.25%	4/15/2024	11.18%	0.09%
Номад	5.13%	4/7/2026	3.54%	-0.02%
Самурай JPY	1.52%	12/25/2023	0.88%	-0.02%

Онцлох мэдээ

- Японы төв банкны үйлдвэрлэгчдийн худалдан авалтын урьдчилсан индекс улирлын тохируулга хийгдсэн байдлаар 3-р сард 51.4 нэгжээс 52 нэгж хүрч өсжээ.
- Өмнөд Солонгосын төв банкны ерөнхийлөгч өнөөдөр өгсөн ярилцлагадаа хэдийгээр эдийн засаг энэ жилд өмнө төсөөлж байснаас хурдацтай сэргэж байгаа ч мөнгөний бодлогоо чангатгахаар яарахгүй гэдгээ мэдэгдлээ.
- Ройтерс агентлагт ирсэн эх сурвалжуудын мэдээллийн дагуу Колумб улс Конгресстоо өргөн барьсан татварын шинэчлэлийн төслийн хүрээнд өмнө дурдаж байсан татвараас цуглуулах мөнгөө өсгөж, 25.4 их наяд песо (\$7.15 тэрбум) болгожээ. Уг төсөлд 10.5 их наяд песог НӨАТ болон ААН, иргэдээс цуглуулах бусад татварын санхүүжилтээс бий болгох юм байна.

Валютын зах зээл

АНУ-ын татварын болзошгүй өсөлт болон Европт дэгдээд буй цар тахлын 3 дахь давлагаа зэрэг нь эрсдэл багатай ам.долларын ханшийг 4 сарын дээд цэг рүү ойртууллаа. Ам.долларын индексийн тухайд Азийн эхний арилжаагаар 2 долоо хоногийн дээд цэг 92.412 нэгжид хүрсэн ба энэ нь 4 сарын дээд цэг 92.506 холгүй үзүүлэлт болоод байна.

Еврогийн ханш ам.долларын эсрэг 4 сарын доод цэг 1.1836 нэгж хүрсэн бөгөөд Герман улс хөл хориог сунгаж, улаан өндөгний баярын өдөр гэртээ байхыг уриалсан нь үүнд нөлөөлжээ. Эрсдэлтэй багатай Японы иенийн ханш ихэнх валютуудын эсрэг чангарсан дүр зураг ажиглагдсан бол Австрали долларын ханш суларсан хөдөлгөөн үзүүллээ. Тодруулбал, Австрали долларын ханш 0.75985 нэгж рүү буурсан нь сүүлийн нэг сарын гаруй хугацааны муу үр дүн бол иенийн эсрэг 82.49 нэгж байгаа нь энэ сарын эхлэлээс хойших хамгийн тааруу хослол болоод байна.

Алтны зах зээл

Лхагва гарагт АНУ-ын засгийн бондын өгөөж 7 хоногийн доод цэгт хүрснээр Холбооны нөөцийн банкны тэргүүн Жером Пауэлл ам.долларын хүч чадлыг бататгасан инфляци удирдлагаас алдагдахгүй гэсэн мэдэгдлийг үл харгалзан алтны ханш өслөө. 1 унц алтны спот ханш өглөөний байдлаар 0.3% өсөлттэй 1,731.75 ам.доллар байна. АНУ-ын алтны фьючерс GCv1 0.4% дээшилж 1,732.70 ам.доллар боллоо.

Зэсийн зах зээл

Европт COVID-19-н халдварууд ихэссэнтэй холбоотой хүмүүсийн айдас аюул багатай ам.долларын эрэлтийг өсгөж улмаар зэсийн үнэ өнөөдөр буурлаа. Мөн Хятад болон Барууны хоорондын хурцадмал харилцаа зах зээлийн төлөв байдалд нөлөөлөв. Лондонгийн Металлын Бирж дээрх зэсийн үнэ 11:04 цагт 0.6% унаж нэг тонн нь \$8,923.50-р арилжаалагдсан бол Шанхайн Фьючерсийн

Хувьцаа	Ханш	24Н Chg
Turquoise Hill Resources	16.78	-6.47%
Mongolian Mining Corp	1.87	-7.43%
Erdene Resource Dev	0.39	-2.50%
Centerra Gold	10.97	-3.01%

Макро эдийн засаг (Монгол)	Огноо	Дүн
Инфляцийн түвшин	2021 (II)	2.6%
Бодлогын хүү	2020 (XI)	6.0%
Банк хоорондын зах зээлийн хүү	2021 (II)	6.25%
Хадгаламжийн дундаж хүү (төг)	2021 (II)	8.6%
Хадгаламжийн дундаж хүү (валют)	2021 (II)	3.1%
Зээлийн дундаж хүү (төг)	2021 (II)	16.39%
Зээлийн дундаж хүү (валют)	2021 (II)	9.97%

Ханшийн таамаглал

Валют	Q2 21	Q3 21	Q4 21	Q1 22	2022
EUR/USD	1.21	1.22	1.24	1.24	1.25
GBP/USD	1.38	1.39	1.4	1.42	1.44
USD/CNH	6.42	6.39	6.36	6.35	6.15
USD/JPY	105	105	105	105	105
USD/RUB	72.6	72.0	71.0	70.6	70.0

Түүхий эд

Алт	1800	1800	1800	1800	1750
Зэс	8375	8075	8100	8100	8060
Нүүрс	55.0	53.25	57.0	57.0	56.63

Эдийн засгийн голлох тоо мэдээ эх сурвалж: Блүүмбэрг

Өмнөх өдрийн үр дүн	Үр дүн	Таам.	Өмнөх
UK Claimant Count Unem Chg	86.6k	-	-20k
UK ILO Unemployment Rate	5.0%	5.2%	5.1%
UK New Home Sales-Units	0.775M	0.876M	0.923M

Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
JP Jibun Bank Mfg PMI Flash	8:30	-	51.4
FR Markit Mfg Flash PMI	16:15	56.5	56.1
GE Markit Mfg Flash PMI	16:30	60.8	60.7
EU Markit Mfg Flash PMI	17:00	57.7	57.9
UK Flash Manufacturing PMI	17:30	55.0	55.1
US Durable Goods	20:30	0.8%	3.4%
US Markit Mfg PMI Flash	21:45	59.3	58.6

Маргааш хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
FR Business Climate Mfg	15:45	98.0	97.0
US GDP Final	20:30	4.1%	4.1%
US Initial Jobless Claims	20:30	730k	770k

Бирж дээр 1.2% унаж 66,290 юань (\$10,162.19)-тай тэнцлээ.

Газрын тосны зах зээл

Өчигдрийн арилжаагаарх уналтын дараа хөрөнгө оруулагчид хямд үнээр арилжаа хийх боломжийг эрж эхэлснээр газрын тосны ханш бага зэрэг өсжээ. Гэхдээ Европ тив дэх тахлын хөл хорио болон АНУ-ын нефтийн нөөцийн өсөлт нь илүүдэл нийлүүлэлт бий болно гэсэн айдсыг нэмэгдүүлж, ханшийн өсөлтийг хязгаарласан байна. Brent тос өмнөх арилжаагаар 5.9% унаж доош \$60.50-г хүрсний дараа өнөөдөр 09:08 цагийн байдлаар 0.4% (27 цент)-ийн өсөлттэй \$61.06-р арилжаалагдав. WTI тос мөн адил 6.2% унаж \$57.32 хүрээд өглөөний арилжаагаар 0.3% (19 цент)-иар дээшилж \$57.95-р арилжаалагдлаа.

АНУ-д илүү их вакцины тунгууд үйлдвэрлэгдэж эхэлснээр эрчим хүчний компаниуд ажилчдаа ажлын байран дээрээ вакцинжуулах зохион байгуулалтыг хийж байгаа хэмээн Ройтерс агентлагт мэдээлжээ.

Бондын зах зээл

Гадны хөрөнгө оруулалтын сангуудын Азийн хөгжиж буй зах зээлээс худалдан авсан бонд өндөр дүнтэй байлаа. Тодруулбал, Блүүмбергийн цуглуулсан мэдээллээр гадны сангууд 3-р сарын 22-нд цэвэр дүнгээр 635.5 сая ам.долларын Өмнөд Солонгос улсад бүртгэлтэй бондуудаас худалдан авсан ба 22-нд цэвэр дүнгээр 52.4 сая ам.долларын Энэтхэг улсын бондуудын орох урсгал их байлаа.

Хөрөнгийн зах зээл

Коронавирусын хөл хорио Европт давамгайлж, АНУ-ын татвар нэмэгдэх магадлал хөрөнгө оруулагчдын эрсдэл даах чадварыг давснаар эрсдэл багатай зүйл рүү тэмүүлэх болжээ. Газрын тос унаж, ам.доллар 4 сарын дээд цэг рүү ойртсоор Азийн хувьцаа Лхагва гарагт 2 долоо хоногийн доод хэмжээнд хүрлээ. Японы Nikkei 1.8%, Өмнөд Солонгосын KOSPI 0.5%, Хонг Конгийн Hang Seng 1.7% тус тус унасан бол БНХАУ-ын CSI300 ягаан хуудасны хувьцааны индекс хоёр дахь өдөртөө улаанаар эргэж 1.2% буураад байна. Уолл Стрийтэд Dow Jones Industrial Average 0.94%, S&P500 0.76%, Nasdaq Composite 1.12% тус тус алдагдалтай хаагдлаа.

Мэдэгдэл

Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгддэг бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдлад ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт харууллага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин ут и-мэйлд харуу илгээнэ үү.